

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 20

Багануур дүүрэг

№	Хийх ажлын агуулга	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Хариуцах эзэн	Гүйцэтгэл	Хувь
1	2	3	4	5	6	7
<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p>						
1	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	<p>1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулж, мөрдүүлэх</p> <p>1.2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг дүүрэг болон нийслэлд хүргүүлэх</p> <p>1.3. ХАСХОМ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох</p>	I улирал	Хуулийн зөвлөх	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулж, мөрдлөг болгон ажилласан.</p> <p>Тайланг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Хувийн ашиг сонирхол хөрөнгө оруулгын мэдүүлгийг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлсэн. АТГ-ын мэдээллээр дүгнэлт нь олон нийтэд ил тод нээлттэй танилцуулагдсан.</p>	100%
2	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	2.1. Ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Ахлах мэргэжилтэн	Тайлант онд сул орон тоо гараагүй.	100%
		2.2. Албан хаагчдын жагсаалт, шилжилт хөдөлгөөний мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй мэдээлэх	I-IV улирал	Ахлах мэргэжилтэн	Ажилтнуудын холбоо барих мэдээлэл, тайлант онд чөлөөлөгдсөн болон шинээр орсон албан хаагчдын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан.	100%
3	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	3.1. Албан хаагч бүр нууцын тухай хуульд хамаарахгүй хариуцсан томоохон ажлын талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Бүх албан хаагч	Хамтын ажиллагаа, байгууллагын төлөвлөгөө, тайлан үйл ажиллагааны болон корона вирустэй холбоотой мэдээллүүдийг тогтмол байршуулан ажиллаж байна.	100%
4	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	4.1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан	I улирал	Хуулийн зөвлөх	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинээр	100%

сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулах			ажилд орсон 1 албан хаагчид танилцуулж мөрдөн ажилласан.	
	4.2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд танилцуулах	12 дугаар сард	Ёс зүйн зөвлөл	Тайлант онд ёс зүйн дүрэм зөрчсөн албан хаагч байхгүй.	100%
Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	5.1. Удирдлагаас гаргасан байгууллагын болон хувийн нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Байгууллагын цахим хуудасны "ил тод" цэсний "тушаал, шийдвэр" дэд цэсэнд удирдлагаас үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалуудыг байршуулан ажилласан.	100%
	5.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмыг цахим хуудсанд байршуулах	II улирал	Хуулийн зөвлөх	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бүх хууль тогтоомж, дүрэм, журам болон ковид-19 цар тахалтай холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг цахим хуудсанд байршуулсан.	100%
	5.3. Байгууллагад хийсэн хяналт шалгалтын дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Ахлах мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс байгууллагын 2020 оны үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ, үнэлгээг цахимаар зохион байгуулсан. - Байгууллагын цахим хуудасны мэдээллийн ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 90%-тай дүгнэгдсэн нь 2020 оны үнэлгээнээс 8,4%-аар өссөн. - Цаашид хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 45 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж, төлөвлөгөө болон тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. 	100%
	5.4. Хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээг цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Программ хангамж, бүртгэл мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	УХЭШХ, ХААИС, ШАУИС, ШУТИС -тай 2019-2020 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж 2020 оны биелэлтийг хамтран дүгнэх ажлыг 2021 оны 02 дугаар сард цахимаар зохион байгуулсан.	100%

					Тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн Монхимо ХХК-ийн үйл ажиллагааны жилийн тайланг цахим хуудсанд байршуулж байна.	
6	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	6.1. Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх /утас, санал хүсэлтийн дэвтэр, цахим хуудас/	II улирал	Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг дараах байдлаар бүрдүүлсэн. Үүнд: - Санал хүсэлтийн дэвтэр - Baganuur-itp.mn сайтад Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ цэс - 7021-3292	100%
		6.2. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн мэдээг цахим хуудсанд байршуулах	I-IV улирал	Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг улирал бүрээр гарган НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд, дүүргийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тус тус хугацаанд нь тайлагнан, цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.	100%
Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд: Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх						
7	Төсвийн орлого, түүний зарцуулалт, түүний хуваарьлалтыг олон нийтэд мэдээлэх	7.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар, улирал, хагас жилийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төслийг цахим хуудсанд байршуулсан байх	Тогтсон хугацаанд нь	Нягтлан бодогч	Сарын мэдээ, санхүүгийн улирлын тайлан, гүйцэтгэлийг цахим хуудсанд байршуулж ажилласан.	100%
		7.2. Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах	04.25-ны дотор	Нягтлан бодогч	Цахим хуудас болон шилэн дансанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг байршуулсан.	100%
		7.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг цахим хуудсанд байршуулсан байх		Нягтлан бодогч	Нийслэлийн Төрийн аудитын газраас байгууллагын 2020 оны санхүү, НББ-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр "Зөрчилгүй" дүгнэлт гаргаж гэрчилгээ хүлээн авсан ба дүгнэлтийг	100%

				байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	
	7.4. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	07.01-ний дотор	Нягтлан бодогч	Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 85 дугаартай албан бичгээр нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн.	100%
	7.5. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах	Улирал тутам	Программ хангамж, бүртгэл мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Одоогийн байдлаар гадаадын зээл тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.	-
				Дундаж хувь	100%

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

С.ОТГОНБААТАР